

АРД ДААТГАЛ ХК ШҮҮХЭД ХАРИУЦАГЧААР ОРОЛЦОЖ БАЙГАА ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 5 сарын 10-ны өдрийн 08 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу зохих мэдээллийг танилцуулж байна.

Ард Даатгал ХК нь 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дараах шүүхийн маргаанд **ХАРИУЦАГЧААР** оролцож байна. Үүнд:

№	Нэхэмжлэгч	Маргааны төрөл	Үнийн дүн	Төлөв
1.	Б.А	Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр гаргуулах	23,849,500 төгрөг	Анхан шатны шүүхээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн бөгөөд Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаснаар хянагдаж байна.
2.	Д.Б	Ипотекийн зээлдэгчийн амь насны даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр гаргуулах	74,377,425 төгрөг	Анхан болон давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бөгөөд нэхэмжлэгчээс Хяналтын шатны шүүхэд гомдол гаргаснаар Хяналтын шатны шүүхэд хянагдаж байна.
3.	Л.Л	Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр гаргуулах	17,610,000 төгрөг	Анхан шатны шүүхээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн ба Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаснаар хянагдаж байна.
4.	А.Ж	Тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр гаргуулах	3,697,000 төгрөг	Хариу тайлбарыг шүүхэд гаргасан, шүүх хуралдаан товлөгдоогүй.
	НИЙТ		119,533,925 төгрөг	

Дээрх маргаанууд нь шүүхийн шатанд хянан хэлэлцэгдэж байгаа буюу шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй болно.